



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 1/34

Хархорин сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Засгийн газрын 2024 оны "Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахад шатахууны зардалд зориулж 935,000 (есөн зуун гучин таван мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг эрсдлээс хамгаалах сангаас зарцуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мягмарсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



ГОДГЭРЭЛ

401100067